



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,  
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026.05.13 № 01/375  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Зөвлөмж хүргүүлэх тухай

Баянхонгор аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэг танд холбоотой “Төрийн албаны тухай хууль, ёс зүй, авлига хээл хахуул, ашиг сонирхол хаагуур хэнд үйлчлээд байгааг мэдэхийг хүсэж байна. 2013 оноос өнөөг хүртэл дур зоргоороо авирлаж, мэргэжлийн залуусыг халж, өөрийн ойр дотно хамтран амьдрагч нөхөр, төрсөн ах, бэр, дүү зэрэг хүмүүсээр хүрээлүүлж төрийн албыг эзэнгүй мэт бодож ирсэн. Сүүлийн үед байгууллагын өмч хөрөнгийг үрэн таран хийж, төсвийн мөнгийг өөрийн хүмүүсээр дамжуулж үр дүн нэрээр авч, өөрийнхөө амьдрал ахуйг сайжруулж ховоор ажил хийж, мэдлэг чадвартай залуусыг нухчин дарж байгааг дуулгая. Хамтран амьдрагч Жанчив нь дуртай үедээ ажил хийж дургүй үедээ албаны машин унаж, танхайрч хүн зодож, төрийн албаны нэр төрийг уландаа гишгэж байна” гэх агуулга бүхий гомдол ирсэн тул Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5-д заасны дагуу дотоод хяналт, шалгалт хийж дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 2.2.1.12-д заасны дагуу цаг уурын байгууллагын 100 жил, аймгийн цаг уурын 60 жилийн ойн арга хэмжээнд зориулж иргэд, аж ахуйн нэгж, албан хаагчдаас авсан хандивын орлого, зарлагын дэлгэрэнгүй тайланг Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн шилэн данс <https://shilendans.gov.mn/>, байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдал Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн веб хуудас болон <https://shilen.gov.mn/>-д тус тус 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх;

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны А/80 дугаар тушаал “Төсөвт зохицуулалт хийх тухай”, ЦУОШГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ны А/26 дугаар “Хуваарь батлах тухай” тушаалаар Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд эко ариун цэврийн байгууламжийн ажлын гүйцэтгэлийг хангуулж, биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх;

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан байх тул цаашид зөрчлийг арилгаж өөрийн хамаарал бүхий этгээдийг шууд удирдах, захиргааны шийдвэр гаргахгүй байх;

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулахдаа хуулийн дагуу нээлттэй, ил тод, хяналт тавьж, гэрээний

ерөнхий нөхцөлд гүйцэтгэгчийг хууль бусаар сонгон шалгаруулсан эсхүл хууль бус давуу байдал олж авч гэрээг байгуулсан нь шүүх болон холбогдох байгууллага, албан тушаалтан тогтоосон бол гэрээг цуцлах заалтыг нарийвчлан оруулж байх;

5. Дээд шатны төсвийн захирагчийн баталсан бүтэц орон тоо, төсвийн хязгаарт багтаах, хүний нөөцийн сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, ил тод байдлыг хангах;

6. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, үүсэж болзошгүй төсөв, санхүүгийн эрсдэлийг тодорхойлж, удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, дүгнэлт хийж ажиллах.

ДАРГА



Э.БАТТУЛГА